




ДУНДГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГЫН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА 2023



www.1212.mn



Дундговь аймаг
2024 он

ТАНИЛЦУУЛГЫН АГУУЛГА

Оршил

- Танилцуулгын зорилго
- Танилцуулгын аргачлал

Аж үйлдвэр

- Уул уурхай олборлох салбар
- Боловсруулах аж үйлдвэр
- Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж

Барилга

Харилцаа холбоо

Бүртгэлтэй аж ахуй нэгж

Дотоодын нийт бүтээгдэхүүн

- Аж үйлдвэр, барилгын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн

1. ТАНИЛЦУУЛГЫН ЗОРИЛГО:

Аймгийн эдийн засаг, дэд бүтцийн үндсэн үзүүлэлтээр нэгдсэн танилцуулга бэлтгэн, эдгээр үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлт, цаашдын чиг хандлагыг тодорхойлон, орон нутгийн удирдлага, бодлого хариуцсан ажилтнуудыг мэдээллээр хангах

2. ТАНИЛЦУУЛГЫН АРГАЧЛАЛ:

Статистикийн албан ёсны мэдээ тайланд тулгуурлан холбогдох үзүүлэлтүүдийг тооцож, сүүлийн жилүүдээр харьцуулан дүгнэж, хүснэгт, графикаар, өсөлт бууралтыг харуулж танилцуулгыг бэлтгэлээ.



АЖ ҮЙЛДВЭР

1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

Аймгийн хөгжлийн эхний 50 жил буюу социализмын үеийн хөгжлийн жилүүдэд олсон томоохон амжилтуудын нэг нь орчин үеийн аж үйлдвэрийн салбар үүсч хөгжсөн явдал юм. Тус аймагт 1942 онд нийтийн хоол боловсруулах гуанз байгуулагдсанаар хүнсний болон аж үйлдвэрийн суурь тавигджээ. Улмаар энэ нь өргөжиж 1974 он гэхэд 4 тасагтай 50 гаруй ажилтантай болж, жилдээ 1.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 6 сая төгрөгийн борлуулалт хийж байв. 1986 онд талх , нарийн боов, гоймон, архи, ундаа, сүү боловсруулж үйлдвэрлэх үндсэн 6 цехтэй шинэ үйлдвэр ашиглалтад орсон байна.

Үүнээс хойш 1949 онд аймгийн үйлдвэр хоршооллын артельд 1 мужаантай мод боловсруулах үйлдвэрийн суурь , 1948 онд гар ажиллагаатай хэвлэх үйлдвэр мөн 1961 оны 10 сарын 19-нд Эрдэнэдалай сумын нутаг Элэгний говийн нүүрсний ордод түшиглэн Цагаан овоогийн нүүрсний уурхайг 19 ажилтан, 5 гэр, 2 машинтай ашиглалтад оруулснаар уул уурхай, олборлох салбарын суурь тус тус тавигдснаар Дундговь аймагт аж үйлдвэрийн салбар хөгжиж байсан байна. 1990 оны нийгэм эдийн засгийн өөрчлөлтөөр эдгээр үйлдвэрүүд хувьд шилжин ажиллаж байна.

2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл

Манай аймагт 2023 оны жилийн эцсийн байдлаар аж үйлдвэрийн 4 салбарт үйл ажиллагаа явуулахаар 182 аж ахуй нэгж бүртгэлтэй байгаагаас 52 нь буюу 28.6 хувь нь үйл ажиллагаа явуулж байгаагаас уул уурхай олборлох аж үйлдвэрийн салбарт 9, боловсруулах салбарт 30, цахилгаан хий, уур агааржуулалтын салбарт 10, усан хангамж, бохир ус, хог, хаягдлын

менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт 3 аж ахуйн нэгж үйлдвэрлэл эрхэлж байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2023 онд /оны үнээр/ 55.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 89.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийжээ. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулахад 67.4 хувиар буюу 22.5 тэрбум төгрөгөөр өссөн байна. Дээрх өсөлтөд уул уурхай олборлох аж үйлдвэр 78.8 хувь, усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар 50.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, ӨСӨЛТИЙН ХУВЬ




ХҮСНЭГТ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар, сая.төг

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР	2018	2019	2020	2021	2022	2023	23/22
НИЙТ ДҮН	9330.3	10445.6	13080.9	21573.4	33350.5	55816.2	167.4
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	3648.3	4606.3	6746.5	14881.2	25922.0	46359.2	178.8
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ	1225.8	1287.8	1308.4	1618.5	1970.3	2031.8	103.1
ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ	3773.3	3787.0	4243.4	3266.2	3740.0	4838.6	129.4
УС ХАНГАМЖ; СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	682.9	764.5	782.6	1807.5	1718.2	2586.6	150.5

2023 оны аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын бүтцийг өмнөх онтой харьцуулбал уул уурхай олборлох аж үйлдвэрийн салбар 83.1 хувь болж, 5.4 нэгж хувиар өссөн бол, боловсруулах аж үйлдвэрийн салбар 3.6 хувь болж, 2.3 нэгж хувиар, цахилгаан хий, уур агааржуулалтын салбар 8.7 хувь болж, 2.5 нэгж хувиар, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар 4.6 хувь болж 0.6 нэгж хувиар тус тус буурсан байна.

ЗУРАГ 2. ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЦ, сүүлийн 3 жилээр, хувиар



1.1 УУЛ УУРХАЙ ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭР

Дундговь аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл 14 сумын нутагт давхардсан тоогоор 125, хайгуулын тусгай зөвшөөрөл 15 сумын нутагт 72, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл 56 бүртгэлтэй байна.

ХҮСНЭГТ 2. АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН БАЙДАЛ


Сумын нэр	Ашиглалтын тусгай зөвшөөрөл		Хайгуулын тусгай зөвшөөрөл		Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл		Бүгд	
	тоо	Талбай га	тоо	Талбай га	тоо	Талбай га	Тоо	Талбай га
Сайнцагаан	6	5482.2	3	5073.31	2	118.63	11	10674.14

Адаацаг	3	1057.27	2	6747.46	1	61.55	6	7866.28
Баянжаргалан	34	46159.7	6	23966.03	6	1088.57	46	
Говь-Угтаал	12	7864.7	4	6319.63	0	0	16	14184.33
Гурвансайхан	19	81810.76	8	72669.22	16	5707.64	43	160187.62
Дэлгэрхангай	23	25434.12	5	53629.99	6	2327.46	34	81391.57
Дэлгэрцогт	0	0	1	625.6	0	0	1	625.6
Дэрэн	0	0	2	4888.6	0	0	2	4888.6
Луус	2	412.88	2	19030.46	2	791.8	6	20235.14
Өлзийт	17	21412.95	8	55219.03	8	2200.61	33	78832.59
Өндөршил	9	29203.59	16	126542.85	10	2863.24	35	158609.68
Сайхан-Овоо	2	1452.4	1	1129.2	2	105.24	5	2686.84
Хулд	5	21953.82	8	36725.68	2	514.39	15	59193.89
Цагаандэлгэр	5	8018.6	5	21050.38	0	0	10	29068.98
Эрдэнэдалай	8	6808.5	1	1367.52	1	338.35	10	8514.37
Дүн /давхардсан/	145	257071.5	72	434985.0	56	16117.5	273.0	724541.37

Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2023 онд 45.4 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 78.8 буюу 20.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 3. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, сая төгрөгөөр



Гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг биет хэмжээгээр өмнөх онтой харьцуулахад нүүрс 24.8 хувиар, жонш 7.5 дахин, гөлтгөнө 2.1 дахин тус тус өссөн байна.


ХҮСНЭГТ 3. УУЛ УУРХАЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2022	2023	23/22
Нүүрс	мян.тн	15	12.8	22.1	233.8	374.4	467.2	124.8
Жонш	мян.тн	9.8	5.6	12.6	19.5	31.1	82.5	265.3
Гөлтгөнө	мян.тн	25.9	16.1	45.6	-	8.5	18	211.8

1.2 БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭР

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2023 онд 2031.8 сая төгрөг болж, өмнөх онтой харьцуулахад 3.1 хувиар өссөн байна. Өсөлт бууралтыг задалж авч үзвэл бусад даавуун эдлэл үйлдвэрлэл 32.7 хувиар, модон, үйсэн үртсэн болон холтсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл 32.4 хувиар, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл 9.6 хувиар тус тус өссөн бол малын тэжээлийн үйлдвэрлэл 24.1 хувиар, үслэг арьсан хувцаснаас бусад хувцас үйлдвэрлэл 61.2 хувиар, хүснэгт маягт үйлдвэрлэл 2.6 хувиар, дээр дурдсан ангид ороогүй төмөрлөг бус эрдэс бүтээгдэхүүний бусад үйлдвэрлэл 58.5 хувиар тус тус буурчээ.

ЗУРАГ 4. БОЛОВСРУУЛАХ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, сая төгрөгөөр



ХҮСНЭГТ 4. БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, сая төгрөгөөр

	2021	2022	2023	23/22 хувь
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ-НИЙТ	1618.6	1970.4	2031.8	103.1

Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1107.7	1424.1	1560.8	109.6
Малын тэжээлийн үйлдвэрлэл	95.5	160.0	121.5	75.9
Бусад даавуун эдлэл үйлдвэрлэл	68.9	49.9	66.2	132.7
Үслэг арьсан хувцаснаас бусад хувцас үйлдвэрлэл	19.7	25.4	9.7	38.2
Модон, үйсэн, үртсэн болон холтсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл	131.0	153.4	203.1	132.4
Хэвлэх болон хэвлэлийн туслах үйл ажиллагаа	27.9	19.5	19.0	97.4
Нэхмэл болон сүлжмэл хувцас үйлдвэрлэл	90.0	13.9	0.0	0.0
Дээр дурдсан ангид ороогүй төмөрлөг бус эрдэс бүтээгдэхүүний бусад үйлдвэрлэл	77.9	124.2	51.5	41.5

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх онтой харьцуулахад талх, нарийн боов, цэвэр ус, модон эдлэл үйлдвэрлэл өссөн бол хүснэгт маягт, чихэр, бялуу, архи, хэрчсэн гурил, хоормог, ааруул оёдол эсгүүрийн үйлдвэрлэл буурсан байна. Боловсруулах аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг сүүлийн 6 жилээр өсөлт бууралтыг хүснэгтэд харууллаа.

ХҮСНЭГТ 5. БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2022	2023	2023/2022%
Хүснэгт маягт	м,х,д,х	320.1	334.2	347.3	398	347.4	339.6	97.8
Талх	тн	126.2	147	149.9	144.7	121.4	133.9	110.3
Нарийн боов	тн	111.5	122.9	133.3	157.1	140.7	162.2	115.3
Чихэр	тн	3.3	2.9	3.7	3	3.9	2.3	59.0
Бялуу	тн	2.1	2.3	1.2	3.2	6.3	3.3	52.4
Архи	мян.л	29.3	25.1	14.8	12.4	15.6	8.9	57.1
Ундаа	мян.л	8.6	0.2	0		0	0	-
Цэвэр ус	мян.л	24.1	50.3	12.1	7.5	1.3	2.7	207.7
Хэрчсэн гурил	тн	4.2	3.1	4.3	35.9	29.2	15.3	52.4
Хиамны зүйл	тн	0.8	0.5	1.3	0.3	0	0	-
Сүү/Тараг	мян.л	6	9.5	0.4	0	0	0	-
Хоормог	мян.л	0.5	0.8	0.3	0	0.4	0.3	75.0
Ааруул	тн	3.3	1.2	0.3	0.3	0.7	0.4	57.1
Оёдол эсгүүр	сая.төг	54.4	27.7	33.2	109.7	39.3	9.7	24.7
Модон эдлэл үйлдвэрлэл	сая.төг	151.6	125.5	221	131	153.4	203.1	132.4

Аймгийн боловсруулах бусад салбарын үйлдвэрлэлийн дийлэнх хувийг жижиг дунд бизнес эрхлэгчид бүрдүүлж байна. Монгол улсын төрөөс жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор тогтмол хэрэгжүүлдэг сангуудын мэдээллийг харвал "Жижиг дунд үйлдвэрийг

дэмжих сан"-гаас 2016, 2017, 2018, 2021 онд тус аймагт зээл олгогдоогүй, Жижиг дунд үйлдвэрийн бодлогын сангаас 2017 онд 1 ААНБ 1 төсөл, 2018 онд 2 ААНБ 2 төсөлд нийт 900 сая төгрөгийн зээл авсан байна. 2019 онд тус аймагт "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан" –аас 1 тэрбум төгрөг хуваарьлагдснаас үйлдвэрлэл эрхлэгчдэд 755.0 сая төгрөгийн зээл олгогдсон бөгөөд 2020 онд ЖДҮДС-аас 470 сая төгрөг, 2022 онд 220 сая төгрөг, 2023 онд 12 аж ахуйн нэгж байгууллагад 1409.4 сая төгрөгийн зээл олгожээ.

Мөн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилготой сум хөгжүүлэх сан 2022 оноос Хоршоо хөгжүүлэх сан болж үйл ажиллагаа явуулж байна. Хоршоог хөгжүүлэх сан 2023 онд аймгийн хэмжээнд 1297.1 сая төгрөгийн зээлийг олгосон бөгөөд үүний үр дүнд 58 ажлын байр хадгалагдаж, 50 ажлын байр шинээр бий болсон байна.

ХҮСНЭГТ 6. 2023 ОНЫ СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сум	Ажлын байр		Олгогдсон зээл /сая төгрөгөөр/	Үйл ажиллагааны чиглэл					
	Хадгалагдсан	Шинээр бий болсон		Хүнсний үйлдвэр	Хөнгөн үйлдвэр	Газар тариалан	Хөдөө аж ахуй	Үйлчилгээ	Бусад
Сайнцагаан	7	11	348.0	1	1	1	2	1	1
Адаацаг	6	6	141.2	1	0	2	0	1	2
Баянжаргалан	5	8	137.0	2	0	3	0	0	0
Говь-Угтаал	1	0	40.0	0	0	1	0	0	0
Гурвансайхан	0	0	-	0	0	0	0	0	0
Дэлгэрхангай	7	5	158.4	0	0	1	2	2	2
Дэлгэрцогт	0	0	-	0	0	0	0	0	0
Дэрэн	14	8	104.0	0	3	2	4	4	1
Луус	0	0	-	0	0	0	0	0	0
Өлзийт	7	8	103.5	0	0	1	0	0	6
Өндөршил	0	0	-	0	0	0	0	0	0
Сайхан-Овоо	1	0	25.0	0	0	0	0	0	1
Хулд	6	0	115.0	0	0	2	0	4	0
Цагаандэлгэр	4	4	125.0	1	1	2	0	0	0
Эрдэнэдалай	0	0	-	0	0	0	0	0	0
Дүн	58	50	1297.1	5	5	15	8	12	13

Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуйн газар


1.2 ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ

Дундговь аймгийн төв болон 14 сум бүхэлдээ төвлөрсөн эрчим хүчний системд холбогдсон бөгөөд тус аймагт Багануур-Зүүн өмнөд бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК-ий Дундговь Цахилгаан Түгээх сүлжээ салбар ажиллаж байна. Дулаан хангамжийн хувьд аймгийн төв Сайнцагаан сумын аж ахуйн нэгжүүд болон аймгийн айл өрхийн хэрэглэгчдэд Ган-Илч ХХК,

Дундговь-Ус ОНӨУҮГ, Есөн-Эрдэнэ эв констракш ХХК, Ирмүүнтүшиг ХХК-ууд дулаан үйлдвэрлэн түгээж байна. Мөн аймгийн нийт 14 сум бүгд төвлөрсөн халаалтын системд холбогдоод байгаа бөгөөд үүнээс 6 суманд Ган-Илч компани дулаанаар ханган ажиллаж байна.

Цахилгаан, хий, уур агааржуулалтын салбар 2023 онд 4838.6 сая төгрөг болж өмнөх оноос 29.4 хувиар буюу 1098.6 сая төгрөгөөр өссөн байна. Энэ салбарын гол бүтээгдэхүүн нь тус аймгийн хувьд дулаан үйлдвэрлэл бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар биет хэмжээ 156.8 мянган гкал болж, өнгөрсөн онтой харьцуулбал 21.9 хувиар өссөн байна /Зураг.5/

ЗУРАГ 5. ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТЫН САЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ



1.4 УС ХАНГАМЖ, СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дундговь аймгийн төв болон 14 сумын нийт хүн амын цэвэр усны хэрэглээг газрын гүний усаар хангаж байна. Тус аймгийн усан хангамж болон цэвэр бохир усны хангамж ариутгалын салбарт Дундговь-Ус ОНӨУГ дангаараа үйл ажиллагаагаа явуулж аймгийн иргэдийн хэрэгцээг ханган ажиллаж байна. Дундговь –Ус ОНӨУГ нь Дундговь аймгийн төв Сайнцагаан сумын хүн ам, албан газар, аж ахуйн нэгжийг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулж цэвэрлэн халдваргүйжүүлэх, нийтийн халуун усны ашиглалт, 2.1, 0.5 мв хүчин чадалтай нам даралтын зуухны ашиглалтыг хариуцаж дулаан үйлдвэрлэх түгээх үйлчилгээг холбогдох тусгай зөвшөөрлүүдийн дагуу хариуцан ажилладаг 100 хувийн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар юм. Мөн 2023 оноос Тэвшийн говь ХХК-ны халаалтын зуухыг орон нутгийн удирдлагын шийдвэрээр хариуцан ажиллуулж эхлэсэн.

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын үйлдвэрлэл 2023 онд 2586.6 сая төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 50.5 хувиар буюу 868.4 сая төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 7. САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2022	2023	2023/ 2022
Түгээсэн цэвэр ус	мян.м3	121.9	140.6	142.3	281.1	219.6	279.1	127.1
Сувагжуулалт	мян.м3	84.7	83.2	94.5	176.5	147.2	186.5	126.7
Зайлуулсан хог хаягдал	мян.тн			84.9	73.3	78.9	94.2	119.4

Салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг биет хэмжээгээр авч үзвэл түгээсэн цэвэр ус 27.1 хувиар, сувагжуулалт 26.7 хувиар, зайлуулсан хог хаягдал 19.4 хувиар тус тус өссөн байна.



БАРИЛГА

Дундговь аймгийн хэмжээнд 2023 онд 76.5 тэрбум төгрөгийн барилга угсралт их засварын ажил хийгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 50.4 хувиар буюу 25.6 тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэ онд 70.8 тэрбум төгрөгийн барилга угсралтын ажил, 5.7 тэрбум төгрөгийн их засварын ажил хийжээ.

/Хүснэгт-7, Зураг 6 /

ЗУРАГ 6. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, сая төгрөгөөр



2023 онд 11973.8 сая төгрөгийн орон сууцны барилга, 5989.5 сая төгрөгийн үйлдвэрийн зориулалттай барилга, 3978.2 сая төгрөгийн худалдаа үйлчилгээний зориулалттай барилга, 2918.9 сая төгрөгийн эмнэлгийн зориулалттай барилга, 58 сая төгрөгийн сүм хийдийн зориулалттай барилга, 4997.4 сая төгрөгийн цэцэрлэгийн барилга, 6283.4 сая төгрөгийн сургуулийн барилга, 63.6 сая төгрөгийн соёлын салбарын барилга, 5876.5 сая төгрөгийн спорт

биеийн тамирын барилга, 355.5 сая төгрөгийн конторын барилга, 803.0 сая төгрөгийн орон сууцны бус бусад барилга, 10135.2 сая төгрөгийн эрчим хүчний барилга, байгууламж, 243.2 сая төгрөгийн холбооны байгууламж, 559.8 сая төгрөгийн хатуу хучилттай зам, 12954.4 сая төгрөгийн далан, суваг шугам, 3650.2 сая төгрөгийн бусад зам талбайн ажил хийгдсэн бол 5688.2 сая төгрөгийн барилгын их засварын ажлууд тус тус хийгдсэн байна.

ХҮСНЭГТ 8. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, сая төгрөг

Барилгын төрөл	2018	2019	2020	2021	2022	2023	23/22 хувь
Нийт	9515	146165	25656	32665	50875.3	76528.6	150.4
Орон сууцны барилга	700	3485	465	7265	735	64.5	8.8
Орон сууцны барилга, үйлчилгээтэй				1020	80	0	0.0
Орон сууцны барилга, гарааштай		800	2680	964	11502.5	11909.3	103.5
Үйлдвэрийн					11311	5989.5	53.0
Худалдаа, үйлчилгээний	3330.5	678.3	1375.3	2691.8	290.3	3978.2	1370.4
Эмнэлэг	1350	1872	5268	3017	862	2918.9	338.6
Сүм хийд						58.0	-
Цэцэрлэг		3272.1	1333.5	0	160	4997.4	3123.4
Сургууль	1509.9	4062.5		1741.6	5038.1	6283.4	124.7
Соёлын		944.8	1142.3	2652.6	2538.1	63.6	2.5
Спорт, биеийн тамир	629	0	2205	0	2185	5876.5	268.9
Конторын	85	3739	2147.4	1340	2198.3	355.5	16.2
Орон сууцны бус бусад барилга	1254.2	728.4	1302.2	1025.4	2228.9	803.0	36.0
Эрчим хүчний	97.5	125760		230	4503.4	10135.2	225.1
Холбооны						243.2	-
Хатуу хучилттай авто зам	-	-	1958	242	496.6	559.8	112.7
Сайжруулсан хөрсөн зам	-	-	70	7647.2	0	0	-
Далан, суваг, шугам	15.7	0	4589.5	403.8	3546.5	12954.4	365.3
Бусад (бусад зам, талбайн ажил)	-	124.4	367.8	0	822.6	3650.2	443.7
Орон сууцны барилгын их засвар	543.2	-	282.7	986.7	264.1	582.6	220.6
Орон сууцны бус барилгын их засвар	-	698	468.8	0	1263	5021.8	397.6
Инженерийн барилга байгууламжийн их засвар	-	-	-	0	849.9	83.6	9.836451
Төмөр бетон гүүр, гүүрэн гарц				1437.7			-

ХАРИЛЦАА ХОЛБОО

Харилцаа холбоо: Дундговь аймгийн бүх сумд шилэн кабельд холбогдсон бөгөөд сумдууд шилэн кабель ашиглаж өндөр хурдаар интернетэд холбогддог. Мөн Юнител группын Юнивишн компани, Монголын Цахилгаан холбоо компани өрхийн интернетийн холбоос, телевизийн суваг, суурин утас гурвыг нэгтгэсэн гурвалсан үйлчилгээг үзүүлж байна. Үүрэн телефоны сүлжээний хувьд юнител, мобиком, жимобайл бүх сумдад, скайтел ХХК 12 суманд /Сайхан-овоо, Өлзийт, Дэлгэрхангай сумдын сүлжээ ажиллахгүй байгаа/ сүлжээтэй, мобиком, юнител компаниуд бүх сумдад 4 жи технологи нэвтрүүлж хэрэглэгчиддээ өндөр хурдны интернет ашиглах боломжийг хангаж өгсөн байна. Мөн 2023 онд Сайнцагаан сумын Мандал багт 2 сүлжээ дэмжих станц барьсан бол скайтел компани Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Цагаандэлгэр сумдад 4 жи технологи нэвтрүүлсэн байна.

ХҮСНЭГТ 9. ҮҮРЭН ТЕЛЕФОНЫ СҮЛЖЭЭ

Сумд	Мобиком	Скайтел	Юнител	Жи-Мобайл
Сайнцагаан	4жи	4жи	4жи	4жи
Адаацаг	4жи	3жи	4жи	3жи
Баянжаргалан	4жи	3жи	4жи	3жи
Говь-Угтаал	4жи	3жи	4жи	3жи
Гурвансайхан	4жи	3жи	4жи	3жи
Дэлгэрхангай	4жи	-	4жи	4жи
Дэлгэрцогт	4жи	4жи	4жи	3жи
Дэрэн	4жи	3жи	4жи	3жи
Луус	4жи	3жи	4жи	3жи
Өлзийт	4жи	-	4жи	3жи
Өндөршил	4жи	3жи	4жи	3жи
Сайхан-овоо	4жи	-	4жи	3жи
Хулд	4жи	3жи	4жи	3жи
Цагаандэлгэр	4жи	4жи	4жи	3жи
Эрдэнэдалай	4жи	4жи	4жи	4жи

Мэдээлэл харилцаа, холбооны салбарын орлого 2023 онд 8327.9 болж сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 31.5 хувиар өссөн байна. Мэдээлэл, харилцаа, холбооны салбарын нийт орлогын 85.9 хувийг цахилгаан холбооны үйл ажиллагааны орлого эзэлж байна.

ЗУРАГ 7. ХОЛБООНЫ САЛБАРЫН ОРЛОГО, сая төгрөгөөр



Харилцаа холбооны салбарын үзүүлэлтүүд 2023 онд өмнөх онтой харьцуулахад суурин телефон цэгийн тоо 1.8 хувиар, үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчийн тоо 2.5 хувиар, нийт интернэт хэрэглэгчийн тоо 59.3 хувиар тус тус буурсан бол кабелийн телевизорын хэрэглэгчид 3 хувиар өсжээ.

ХҮСНЭГТ 10. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018	2019	2020	2021	2022	2023	23 /22%
Нийт орлого	сая.төг	5 454.2	6 334.2	5 861.9	5 855.9	7698.3	8327.9	108.2
Өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагааны орлого	сая.төг	404.5	699.8	466.8	513.8	1088.0	1171.0	107.6
Цахилгаан холбооны үйл ажиллагааны орлого	сая.төг	5049.7	5634.4	5395.1	5342.2	6610.3	7156.9	108.3
Суурин телефон цэг	тоо	723.0	751.0	870.0	981.0	1047.0	1028.0	98.2
Үүрэн утасны идэвхтэй хэрэглэгч, , аймгийн дүнгээр (давхардсан тоогоор)	тоо	55198.0	57167.0	53796.0	55771.0	58821.0	57337.0	97.5
Кабелийн телевизийн хэрэглэгчид	тоо	10315.0	11697.0	12530.0	13160.0	14157.0	14584.0	103.0
MMDS/DTV/	тоо			222.0	244.0	279.0	172.0	61.6
АйПиТиВи /IPTV/	тоо			733.0	923.0	1335.0	1498.0	112.2
Хиймэл дагуулаар	тоо			11575.0	11993.0	12543.0	12914.0	103.0
Нийт интернэт хэрэглэгчид	мян.хүн	-	-	41.0	43.4	117.3	47.7	40.7



БИЗНЕС РЕГИСТРИЙН САН.


Статистикийн бизнес регистрийн санд 2023 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 1399 аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаа нь өмнөх оноос 60 аж ахуйн нэгжээр буюу 4.9 хувиар өсжээ. Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 374 буюу 26.7 хувь нь төрийн болон төрийн бус байгууллага, 824 буюу 58.9 хувь нь компани, 79 буюу 5.6 хувь нь нөхөрлөл, 100 буюу 7.1 хувь нь хоршоо 22 нь буюу 1.6 хувь нь ТӨҮГ, ОНӨҮГ байна. Нийт аж ахуйн нэгжийг үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, сумаар хүснэгтэд харууллаа.

ХҮСНЭГТ 11. БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, СУМААР, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДЛААР

Сумд	Үйл ажиллагаа явуулж байгаа		Үйл ажиллагаа эхлээгүй		Үйл ажиллагаа түр зогсоосон		Үйл ажиллагаа бүрэн зогсоосон		Нийт	
	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023
Бүгд	627	653	84	125	584	587	41	34	1339	1399
Сайнцагаан	342	357	40	69	349	348	15	13	746	787
Адаацаг	19	19	4	5	19	23	6	1	48	48
Баянжаргалан	18	21	5	5	26	25	1	2	50	53
Говь-Угтаал	17	17	1	2	14	15	1	1	33	35
Гурвансайхан	22	23	5	6	21	21	1	1	49	51
Дэлгэрхангай	22	23	2	3	10	8	0	1	34	35
Дэлгэрцогт	19	18	2	4	7	6	1	2	29	30
Дэрэн	17	19	1	1	6	7	1		25	27
Луус	16	16	4	5	19	19	1	1	40	41
Өлзийт	20	21	4	5	23	25	2	1	49	52
Өндөршил	18	17	2	3	24	27	5	3	49	50
Сайхан-Овоо	26	26	3	6	17	14	0	2	46	48
Хулд	31	29	1	1	22	23	1	1	55	54
Цагаандэлгэр	12	14	4	5	11	10	0		27	29
Эрдэнэдалай	28	33	6	5	16	16	6	5	56	59

Нийт ААНБ-ын 46.7 хувь нь буюу 653 ААНБ, байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААНБ болон үйл ажиллагаа идэвхтэй явуулж байгаа ААНБ-ын тоог сүүлийн жилүүдээр графикт харууллаа. /Зураг.8/

ЗУРАГ 8. БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ ААНБ, ҮҮНЭЭС ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ААНБ-ЫН ТОО



Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг салбараар авч үзвэл 36.4 хувь буюу 238 нь бөөний болон жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна.

ХҮСНЭГТ 12. БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙ НЭГЖИЙН ТОО, эдийн засгийн салбараар

Салбар	2018	2019	2020	2021	2022	2023
Бүгд	622	645	574	578	627	653
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	14	12	10	12	12	13
Уул уурхай, олборлолт	9	9	6	6	5	9
Боловсруулах үйлдвэрлэл	32	31	32	28	31	30
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	4	4	5	5	6	10
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	3	3	2	2	2	3
Барилга	14	16	14	16	21	22
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	196	192	195	199	226	238
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2	4	4	6	7	6
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	24	26	23	22	27	26
Мэдээлэл, холбоо	3	6	4	4	4	4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	23	22	18	17	18	18
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	4	5	4	4	4	5


Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	51	53	50	51	57	58
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	13	13	12	13	17	17
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	49	49	49	49	50	51
Боловсрол	53	54	53	54	54	53
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	42	41	38	39	40	41
Урлаг, үзвэр, тоглоом наадам	20	20	20	19	19	18
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	66	85	35	32	27	31

5. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

Дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/ нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд дотоод гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нэг жилийн хугацаанд шинээр бий болгосон нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм. ДНБ-ийг үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын гэсэн 3 аргаар тооцдог бөгөөд Аймгийн ДНБ-ийг Монгол улсын Үндэсний Статистикийн хорооноос харьяатын зарчмыг баримтлан тооцож байна. Аймаг бүсийн ДНБ-ийг үйлдвэрлэлийн болон орлогын аргыг хослуулан тооцдог.


2023 оны аймгийн ДНБ оны үнээр урьдчилсан гүйцэтгэлээр 521.1 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 25.6 хувиар буюу 106.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 9. ДНБ, зах зээлийн үнээр, тэрбум төгрөгөөр



Дундговь аймгийн ДНБ 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 521.1 тэрбум болсон нь Монгол улсын ДНБ-ий 0.8 хувийг, төвийн бүсийн ДНБ-ий 6.0 хувийг бүрдүүлж байна./Зураг.10/

ЗУРАГ 10. ТӨВИЙН БҮСИЙН ДНБ-ИЙ БҮТЭЦ, хувиар



Аймгийн ДНБ-ийг бусад төвийн бүсийн аймгуудтай харьцуулан сүүлийн 5 жилээр хүснэгтэд харууллаа.

ХҮСНЭГТ 13. ТӨВИЙН БҮСИЙН АЙМГУУДЫН ДНБ, тэрбум төгрөгөөр

	2019	2020	2021	2022	2023*	23/22%
Төвийн бүс	3677.5	4273.2	5046.7	7071.6	8716.9	123.3
Говьсүмбэр	112.6	124.6	139.2	149.5	191.1	127.8
Дархан-Уул	524.2	661.5	766.3	755.7	1175.9	155.6
Дорноговь	460.6	512.9	604.7	655.7	813.8	124.1
Дундговь	372.6	348.6	337.0	414.9	521.1	125.6
Өмнөговь	841.8	1054.3	1145.6	2880.6	3429	119.0
Сэлэнгэ	739.9	867.5	1202.6	1182.2	1384	117.1
Төв	625.8	703.8	851.2	1033.0	1202	116.4

2023 оны ДНБ-ий бүтцийг салбараар авч үзвэл ХАА-н салбар 56.0 хувь, үйлдвэрийн салбар 17.2 хувь, үйлчилгээний салбар 26.8 хувийг тус тус эзэлж байна. ДНБ-ий бүтцийг эдийн засгийн салбараар, сүүлийн 5 жилээр, бүтцээр хүснэгт 14-т харууллаа.

ХҮСНЭГТ 14. ДУНДГОВЬ АЙМГИЙН ДНБ-НИЙ БҮТЭЦ

Салбар	2017	2018	2019	2020	2021	2022	2023*
Аймгийн ДНБ-ий бүтэц, хувиар							
Бүгд	100	100	100	100	100	100	100
Хөдөө аж ахуй	59.9	62.5	59.4	54.1	56.3	57.6	56.0


Үйлдвэрлэл	13.2	13.8	16.7	19.2	14.3	15.2	17.2
Үйлчилгээ	26.9	23.7	23.9	26.7	29.4	27.2	26.8

2023 оны аймгийн нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн оны үнээр урьдчилсан гүйцэтгэлээр 11166.4 мянган төгрөг болж, өмнөх онтой харьцуулбал 26.2 хувиар өссөн байна./Зураг.11/ Дундговь аймаг нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээгээр 21 аймгаас 9-рт эрэмбэлэгдсэн байна.

ХҮСНЭГТ 15. НЭГ ХҮНД НОГДОХ ДНБ, 2017-2023 онуудаар, мянган төгрөгөөр

Нэг хүнд ногдох ДНБ	2017	2018	2019	2020	2021	2022	2023*	23/22 хувь
Улсын дүн	9042.5	10314.1	11855.6	11612.9	13267.9	16121.0	20359.9	126.3
Төвийн бүс	5761.1	6161.1	7227.0	8385.0	9785.6	13367.8	16937.5	126.7
Дундговь	5805.7	6792.3	7968.7	7418.4	7108.9	8850.1	11166.4	126.2

ЗУРАГ 11. НЭГ ХҮНД НОГДОХ ДНБ, мянган төгрөгөөр



2023*- 2023 оны ДНБ-ийг урьдчилсан гүйцэтгэлээр тооцсон болно.

Ашигласан ном материал

1. Монгол улсын статистикийн эмхэтгэл 2017-2023
2. Аймгийн нийгэм эдийн засгийн танинцуулга 2017-2023
3. Дундговь аймгийн товч түүх 1991 он
4. Аймгийн Бизнес регистрийн сан 2012-2023
5. www.nso.mn
6. www.1212.mn

Мэдээлэл авах холбоосууд:

<http://www.dundgovi.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн
дарга Б.Энхтуяа
Утас: (976)-70593777

Дундговь аймгийн статистикийн хэлтсийн
Ахлах мэргэжилтэн Т.Бямбасүрэн
Утас: (976)-70593715, 88057913
Byambasuren@nso.mn

ХАЯГ: ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР 319, 320 ТООТ



/StatisticMGL



Dundgovi@nso.mn



70593715